



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 4/124

Улаанбаатар хот

Туг аялуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3 дахь зорилт, 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хепатитийн В, С вирусын халдварын илрүүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Манай байгууллага элэгний вируст халдвараас хамт олноо хамгаална” уриан дор аж ахуйн нэгж, албан байгууллагад туг аялуулах арга хэмжээг 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. “Манай байгууллага элэгний вируст халдвараас хамт олноо хамгаална” уриан дор туг аялах хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.

3. Хепатитийн вирусын халдварын илрүүлгийн 2 дугаар шатны үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, албан байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080560

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 04 сарын 04-ны өдрийн
А/124 дугаар тушаалын хавсралт

“Манай байгууллага элэгний вируст халдвараас хамт олноо хамгаална” уриан
дор туг аялах хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт

Зорилго

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага хамт олноо идэвхжүүлэх замаар хепатитийн В, С вирусын халдварын илрүүлэгт зорилтот насны иргэдийг бүрэн хамруулах.

Хамрах хүрээ

Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, албан байгууллагууд

Хугацаа

2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэнэ. Туг аялах хугацаа нь аж ахуйн нэгж байгууллагын ажилтны тооноос хамааран өөр өөр байна.

	Ажилтны тоо	Туг аялах хугацаа /ажлын өдрөөр/
1	100 хүртэл	7
2	101-250	10
3	251-500	13
4	501-1,000	15
5	1,000-аас дээш	20

Зохион байгуулах арга хэмжээ

1. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн 2 дугаар шатны ажлын хэсэг аж ахуйн нэгж, албан байгууллагад тугийг гардуулна.
2. Тугийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагааг зохион байгуулна.
 - a. Харьяалах дүүргийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилтан, албан хаагчдыг элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулах;
 - b. Илрүүлэг шинжилгээгээр элэгний В,С вирустэй /HBsAg “эерэг”, anti-HC “эерэг”/ ажилтан, албан хаагчдыг харьяаллын дагуу эрүүл мэндийн байгууллагын хяналтад оруулна;
 - c. Элэгний В,С вирус илэрсэн ажилтан, албан хаагчдыг вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээ, элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэгт оруулах;
 - d. Элэгний В,С вирусын эсрэг эмчилгээ шаардлагатай ажилтан, албан хаагчдыг эмчилгээ хийлгэхэд дэмжлэг үзүүлнэ.

		4. Илрүүлэг шинжилгээгээр элэгний В вирустэй гарсан хүний тоо А) $\frac{1. \text{Элэгний хавдрын илрүүлэгт хамрагдсан хүний тоо}}{2. \text{Элэгний С вирустэй гарсан хүний тоо}} \times 100\% = \text{хувь}$ Б) $\frac{3. \text{Элэгний хавдрын илрүүлэгт хамрагдсан хүний тоо}}{4. \text{Элэгний В вирустэй гарсан хүний тоо}} \times 100\% = \text{хувь}$
6	Элэгний вирус эсрэг эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Насны бүлгээр 1. Элэгний С вирус эсрэг эмчилгээнд орсон хүний тоо 2. Элэгний В вирус эсрэг эмчилгээнд орсон хүний тоо
7	Элэг бүтэн Монгол цахим программд оруулсан хүний тоо	Цахим программд мэдээллийг нь оруулсан илрүүлэг шинжилгээнд хамрагдсан хүний тоо
8	Сургалт сурталчилгааны тоо, хамрагдсан хүний тоо	1. Албан байгууллага дээрээ зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо 2. Хамрагдсан хүний тоо

- е. Ажилтан, албан хаагчдын элэгний В,С вирусын илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх мэдээллийг “Элэг бүтэн Монгол” цахим программд бүрэн оруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
3. Элэгний В,С вирусын халдвараас сэргийлэх талаар ажилтан, албан хаагчид, тэдний гэр бүлд зориулсан мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулна.
 4. Туг хүлээн авсан байгууллага бүр өөрийн таних тэмдэг, лого бүхий туузыг тугны ишинд зүүж, дараагийн байгууллагад шилжүүлнэ.
 5. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн Ажлын хэсэг аж ахуйн нэгж байгууллагаас тайланг авч, шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэн, тугийг дараагийн байгууллагад гардуулна.
 6. Туг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллагыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах арга хэмжээг Ажлын хэсэг зохион байгуулна.

Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Аргачлал, тайлбар
1	Нийт ажиллагсдын тоо /15-40 нас, 40-65 нас, +65 нас/	Хамрагдвал зохих хүний тоог насны бүлгээр гаргасан байна.
2	Ажилтан, албан хаагчдыг элэгний В,С вирусын илрүүлэгт хамруулах хуваарь гаргаж, хуваарийн дагуу хамруулсан хүний тоо/хувь	Насны бүлгээр, элэгний вирусын бүлэг тус бүрээр 1. Илрүүлэгт хамрагдсан хүний тоо /элэгний В, С вирус тус бүрээр/ 2. Хамрагдвал зохих хүний тоо $\frac{\text{1. Илрүүлэг шинжилгээнд хамрагдсан хүний тоо}}{\text{2. Илрүүлэг шинжилгээнд хамрагдвал зохих хүний тоо}} \times 100\% = \text{хувь}$
3	Илрүүлэг шинжилгээг зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах	Хамтран ажилласан тухай тайлан
4	Элэгний В,С вирусын идэвхжил тоолох шинжилгээ хийлгэсэн хүний тоо / хувь	Насны бүлгээр, элэгний вирусын бүлэг тус бүрээр 1. Элэгний С вирусын идэвхжил тоолох шинжилгээ хийлгэсэн хүний тоо 2. Илрүүлэг шинжилгээгээр элэгний С вирустэй гарсан хүний тоо 3. Элэгний В вирусын идэвхжил тоолох шинжилгээ хийлгэсэн хүний тоо 4. Илрүүлэг шинжилгээгээр элэгний В вирустэй гарсан хүний тоо А) $\frac{\text{1. Элэгний С вирусын идэвхжил тоолох шинжилгээ хийлгэсэн хүний тоо}}{\text{2. Элэгний С вирустэй гарсан хүний тоо}} \times 100\% = \text{хувь}$ Б) $\frac{\text{3. Элэгний В вирусын идэвхжил тоолох шинжилгээ хийлгэсэн хүний тоо}}{\text{4. Элэгний В вирустэй гарсан хүний тоо}} \times 100\% = \text{хувь}$
5	Элэгний хорт хавдрын илрүүлэгт хамрагдсан хүний тоо, хувь	Насны бүлгээр, элэгний вирусын бүлэг тус бүрээр 1. Элэгний хорт хавдрын илрүүлэгт хамрагдсан хүний тоо 2. Илрүүлэг шинжилгээгээр элэгний С вирустэй гарсан хүний тоо 3. Элэгний хорт хавдрын илрүүлэгт хамрагдсан хүний тоо